



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ЦАГ УУР, ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР**

Жуулчны гудамж 5, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 41 52, Факс: (976-11) 32 66 11,
Цахим шуудан: info@namem.gov.mn

2025. 11.07 № 01/795.

танай _____-ны № _____-т

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА
С.БЯМБАЦОГТ ТАНАА**

Тус газраас хариуцсан салбарын хүрээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамж, болон албан даалгаврын хэрэгжилт, биелэлтэд судалгаа хийж, давхардал, хийдэл, зөрчлийг арилган, уялдаа холбоог сайжруулах арга хэмжээ авах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллаж тайлан мэдээллийг хүснэгтийн дагуу боловсруулан хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 9...хуудастай.

ДАРГА

Э.БАТТУЛГА

Улсын Их Хурлын тогтоол, УИХ-ын Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжид Цаг уур, орчны шинжилгээний газарт үүрэг болгосон заалтгүй байна. Харин Засгийн газрын тогтоол-13, тэмдэглэл-14, Ерөнхий сайдын захирамж-2, албан даалгавар-1 нийт 38 заалтын давхардал, зөрчил, хийдлийн судалгааг хийхэд Засгийн газрын тогтоол-6, Засгийн газрын тэмдэглэл-1 нийт 8 заалтыг шийдвэр цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон хугацаандаа бүрэн хэрэгжсэн байдлаар "тийм" гэсэн тэмдэглэгээг хийв.

Д/д	Шийдвэрийн нэр батлагдсан огноо дугаар	Заалт	Биелэлт	Тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан		Бодит шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй болсон	Цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон	Тухайн шийдвэр хүчингүй болсон	Шийдвэрт заасан хугацаа дууссан	Чиг үүрэгт хамаарал гүй
				Утга, агуулгын	Шийдвэрийн					
Засгийн газрын тогтоол										
1	Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай 2024-08-07 Дугаар 2024_28	2.6.Өвөл, хаврын улирлын бэлчээрийн даац, зудын эрсдэлийн зураглалыг цаг агаарын урьдчилсан мэдээнд тулгуурлан бодитой тогтоох, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс сэргэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх мэдээг малчид, иргэдэд түргэн шуурхай, цаг алдалгүй хүргэх арга хэмжээ авч, хэрэгжүүлэхийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяад;	2025 оны эхний хагас жилд нийт 13 удаагийн цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдэл ажиглагдсан. Давхардсан тоогоор анхааруулга мэдээ 737, сэргэмжлүүлэх мэдээ 61, урьдчилан сэргийлэх мэдээ 7 удаа гаргаж, олон нийтэд зарлан мэдээлэв. Анхааруулга мэдээг хүчтэй салхиар 76, шороон шуургаар 62, их бороогоор 4, шар усны үерээр 14, нойтон цасаар 86, цасан шуурга 72, ой хээрийн түймрээр 35, хүйтрэлтээр 24 удаа явуулсан. Сэрэмжлүүлэг мэдээг хүчтэй салхиар 32, шороон шуургаар 7, их цасаар 5, цасан шуургаар 16, цочир хүйтрэлтээр 1 удаа, Урьдчилан сэргийлэх мэдээг хүчтэй салхиар 3, шороон шуургаар 2, цасан шуургаар 2 удаа тус бүр олон нийтэд хүргэж ажилласан.	Хүнс, хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай	2025-08-20 Дугаар 2025_56 тогтоол	-	Тийм	-	-	-
		4. Энэхүү тогтоолд заасан арга хэмжээг батлагдсан төсөвтөө багтаан зохион байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын холбогдох агентлагийн дарга нарт үүрэг болгосугай.	Цаг уур, орчны шинжилгээний газар өөрийн төсөвтөө багтаан цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс сэргэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх мэдээг малчид, иргэдэд түргэн шуурхай, цаг алдалгүй хүргэх арга хэмжээ авч ажилласан.			-		-	-	
2	Цацрагийн ослоос хамгаалах үйл ажиллагааны улсын төлөвлөгөө батлах тухай 2020-12-23 Дугаар 2020_228	Хүснэгт 2. Цаг уур, орчны хяналт, шинжилгээний асуудал хариуцсан эрхэлсэн төрийн захиргааны байгууллага орчны цацрагийн хяналтын хэмжилт, шинжилгээг хийх, хэмжилт, шинжилгээний дүн мэдээгээр хангах; -цаг агаарын төлөвийн талаар холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангах.	Засгийн Газрын 2020 оны 228-р тогтоолоор баталсан "Цацрагийн ослоос хамгаалах нэгдсэн төлөвлөгөө"-ний 5.4-р зүйлд заасны дагуу ЦУОШГ нь хөрс, ус, агаарт цацрагийн түвшний хэмжилт хийх үүргийг хүлээсэн. Хүлээсэн үүргийн дагуу Гамма цацрагийн түнгийн чадлын хэмжилтийг 36 цэгт хийж 2020 онд 25298 мөр мэдээ, 2021 онд 24486 мөр мэдээ, 2022 онд 25398 мөр мэдээ, 2023 онд 25592 мөр мэдээ, 2024 онд 26286 мөр мэдээ, 2025 оны 10 сарын байдлаар 19055 мөр мэдээг ЦЭКАА, МХЕГ, НМХГ, Дозиметр тохируулгын лаборатори зэрэг байгууллагуудад хүргэж ажилласан. Мөн Агаар дахь тунадас, тоосонцрын нийлбэр Бетта идэвхийг 25 цэгт хийж 2020-2025 онуудад нийт 1750 мөр мэдээг ЦЭКАА, МХЕГ, НМХГ, Дозиметр тохируулгын лаборатори зэрэг байгууллагуудад хүргэж ажилласан. Болзошгүй ослын үеийн бэлэн байдлын бэлтгэл ажлыг хангах зорилгоор нийлмэл Бета идэвхийн нэмэлт хэмжилтийн үед хэрэглэгдэх фильтрийн цаас 30 ширхгийг урьдчилан захиалж бэлтгэсэн.	-	-	-	-	-	-	
			Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 229 дүгээр тогтоолоор баталсан "Цөмийн материалыг бүртгэх, хяналт тавих журам"-ын 1.2.1; 2.1.1; 2.1.4 дүгээр заалтууд,	Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 229 дүгээр тогтоолоор баталсан "Цөмийн материалыг бүртгэх, хяналт тавих журам"-ын 1.2.1; 2.1.1; 2.1.4 дүгээр заалтууд, 2025 оны байдлаар ЦУОШГ болон түүний харьяа байгууллагуудад 1. Цацрагийн хэмжлийн радиометр багаж -38 ш 2. Агаарын автомат станцын детектор С14 – 24 ш + 25 ш 3. Рентген флюоресценцийн спектрометр – 1ш /компьютер/ ашиглагдаж байна	-	-	-	-	-	

4	Гашуудлын үеийн дэгийн тухай 2025-01-22 Дугаар 2025_26	2.2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 12.00 цагт улс орон даяар автомашин, галт тэрэг, цахилгаан станцын дуут дохиоллыг өгч, төрийн нийт албан хаагчид нэг минут зогсож	2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 12.00 цагт байгууллагын төрийн нийт албан хаагчид нэг минут зогсож хүндэтгэл үзүүлсэн.	-	-	-	Тийм	-	-	-
5	Экспортын орлогыг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай 2025-02-19 Дугаар 2025_94	4.Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, хөрөнгө оруулалт татах зорилгоор гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж болон иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэж ажиллахыг бүх шатны төрийн захиргааны байгууллагад үүрэг болгосугай.	Цаг уур, орчны шинжилгээний газар болон Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн, Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатори, Нислэгийн цаг уурын төв, Улаанбаатар хотын УЦУОШТ-д иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын 2025 оны 3 дугаар улирлын тайлан мэдээг байгууллагын namem.gov.mn цахим сайтад байршуулсан. Тайлангийн хэрэгжилтийн хувьд Цаг уур, орчны шинжилгээний газар-237, УЦУОСМХ -105, НЦУТ-71, БОХЗТЛ-10, УБХУЦУОШТ-59 өргөдөл гомдол бүртгэгдэж утсаар, бичгээр, цахимаар, биечлэн 100 хувийн биелэлтэйгээр шийдвэрлэсэн байна. Харьга байгууллагуудын шийдвэрлэж буй өргөдөл гомдлын агуулгын хүрэн авч үзвэл албан хаагчдаас ирүүлсэн байгууллагын дотоод асуудалтай холбоотой хүсэлт дийлэнх хувийг эзэлж байна. Харин БОХЗТЛ-н баталгаажуулалт хийлгэх тухай, Стандарт батлах санал буюу байгууллагаас үйлчилгээ авах тухай хүсэлтийг шийдвэрлэсэн байна.	-	-	-	-	-	-	-
6	Ажил, амралтын цагийн зохицуулалтын тухай 2025-02-26 Дугаар 2025_109	Монголын үндэстний уламжлалт баяр Цагаан сар: билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн 1 тасарч, шинийн 2,3-ны өдөр Бямба, Ням гарагт тохиож байгаагай холбогдуулан 2025 оны 03 дугаар сарын 03, 04, 05-ны өдрийн Даваа, Мягмар, Лхагва гарагт ажилтан, албан хаагчдыг амрааж, 2025 оны ажлын жилд багтаан нөхөж ажиллуулах зохицуулалт хийхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны засаг дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад даалгасугай.	2025 оны 03 дугаар сарын 03, 04, 05-ны өдрийн Даваа, Мягмар, Лхагва гарагт албан хаагчдыг амрааж, 3 дугаар сарын Бямба гарагт нөхөн ажиллуулсан.	-	-	-	Тийм	-	-	-
7	Олон улсын худалдааны тарифын нөхцөл байдалтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2025-03-12 Дугаар 2025_132	Олон улсад үүсэж байгаа геополитикийн болон худалдааны хурцадмал, тодорхойгүй нөхцөл байдлаар холбогдуулан хүн амд үзүүлэх үйлчилгээний зохицуулалтын уялдааг хангах, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх орчны тогтвортой байдлыг дэмжих зорилгоор төрөөс иргэн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа бүх төрлийн үйлчилгээний төлбөр, хураамжийг 2025 оны төсвийн жилд нэмэгдүүлэхгүй байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нарт зөвлөсүгэй.	Цаг уур, орчны шинжилгээний бүх төрлийн мэдээллийг ажиглалтын цэг бүрээр /өртөө, харуул/ хүссэн хугацаагаар дундаж, хамгийн их, бага, нийлбэрийг гарган авах боломжтой. Цаг уур, орчны шинжилгээний газрын архив, мэдээллийн сангаас үзүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээг 2023 оны 08 дугаар сарын 24-ний өдөр Архивын Ерөнхий газрын даргын А/68 дугаар тушаалаар баталсан. Тус тушаалаар баталсан үйлчилгээний хөлсөөр үйлчилгээг одоогоор үзүүлж байгаа бөгөөд Цаг уур, орчны шинжилгээний газраас 2025 онд иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй үйлчилгээний төлбөр, хураамжийг нэмэгдүүлээгүй.	-	-	-	Тийм	-	-	-
8	Сэлгэн ажлуулах тухай 2025-03-19 Дугаар 2025_149	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрөөс Цаг уур, орчны шинжилгээний газрын даргаар томилогдсон.	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрөөс Цаг уур, орчны шинжилгээний газрын даргаар томилогдсон.	-	-	-	Тийм	-	-	-
9	Арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай 2025-04-02 Дугаар 2025_160	2. Төлөвлөгөөний дагуу эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагааны нарийвчилсэн төлөвлөгөө баталж, биелэлтийг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлаг, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.	Цаг уур, орчны шинжилгээний газраас дохионы хэлмэрчтэйгээр цаг агаарын мэдээлэл хүргэхээр холбогдох төрийн байгууллагатай хамтран ажиллахаар төлөвлөгөө гарган ажиллаж байна.	-	-	-	-	-	-	-

10	Ажил, амралтын цагийн зохицуулалтын тухай 2025-06-04 Дугаар 2025_279	Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярын 2025 оны 07 дугаар сарын 12, 13-ны өдрүүдэд нь Бямба, Ням гарагт тохиож байгаатай холбогдуулан 2025 оны 07 дугаар сарын 16,17-ны өдрийн Лхагва, Пүрэв гарагт ажилтан, албан хаагчдыг амрааж, 2025 онд багтаан нөхөн ажиллуулах зохицуулалт хийхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад даалгасугай.	Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын А/131 дүгээр тушаалаар 2025 оны 06 дугаар сарын 28, 07 дугаар сарын 05-ны өдрийн Бямба гарагт нөхөн ажиллуулах зохицуулалт хийж бүх албан хаагчид тухайн хугацаанд ажилласан.	-	-	-	Тийм	-	-	-
11	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2025-07-23 Дугаар 2025_29	3.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх арга хэмжээний хэрэгжилтийг хангах хүрээнд бүх талын дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг Засгийн газрын агентлагын газрын дарга нарт	Цаг уур, орчны шинжилгээний газрын Хөдөлмөрийн дотоод журамд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хэрэглэх, нэвтрүүлэхийг хориглох нэмэлт заалт оруулахаар ажиллаж байна.	-	-	-	-	-	-	-
12	"Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын тогтоолын төсөл 2025-08-20 Дугаар 2025_52	Улсын Их Хурлын 2024 оны 13 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч"-ийн дагуу Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагийг 1 дүгээр хавсралт ёсоор байгуулан ажиллуулсугай.	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны 08 дугаар сарын 29-ны өдрийн А/692 дугаар "Цаг уур, орчны шинжилгээний газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай" тушаалаар бүтэц, орон тоо батлагдсан.	-	-	-	-	-	-	-
13	Хүнс, хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл	2.19. цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх мэдээг малчид, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд цаг алдалгүй, шуурхай хүргэх арга хэмжээ авч ажиллахыг Цаг уур, орчны шинжилгээний газар (З.Баттулга), аймгийн Засаг дарга нарт	Сэрэмжлүүлэх болон урьдчилан сэргийлэх мэдээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлд: 1. И-Монголиа төрийн үйлчилгээний нэгдсэн платформын 5.0 шинэчлэлийн хүрээнд: а/ "Сонордуулга" цэсээр дамжуулан цаг агаарын сэрэмжлүүлэх болон урьдчилан сэргийлэх мэдээг хүргэдэг боллоо. б/ Сар улирлын онцлогоос харгалзан "Гол мөрний үерийн", "Түймрийн эрсдэл, хуурайшилтын", "Агаарын чанарын" сэрэмжлүүлэг мэдээллийг тогтмол хүргэдэг боллоо. в. Аюулт, гамшигт үзэгдлийн мэдээг хэрэглэгчийн бүртгүүлсэн байршилд тулгуурлан сонгож хүргэх боломжийг бүрдүүлсэн. 2. Цаг агаарын тодорхойлолт, ажиглалтын мэдээ авах процессыг цахимжуулж, хэрэглэгч өөрийн сонгосон үзүүлэлт, хугацаа, нөхцөлөөр www.archive.weather.gov.mn цахим хуудаснаас болон И-Монголиагаар дамжуулан авах боломжийг бүрдүүллээ. Мөн НӨАТ-ийн баримт, мэдээ баталгаажуулалтын хуудсыг цахимаар авах боломжтой болсон. 3. 8-р сарын 28-наас эхлэн цаг агаарын үндсэн мэдээллүүдийг хиймэл дагуулын зурагтай нэгтгэж, бодит цагийн мэдээллийг эх хэл дээрээ газрын зургаас үзэх бололцоог бүрдүүллээ. Үзэгдэл, температур, даралт, салхины хурд, чиглэлийг үүл, үер, аюултай үзэгдэл, хуурайшилтын мэдээтэй сонгосон байршилд, хүссэн байдлаараа давхцуулан харах боломжийг www.weather.gov.mn/map бүрдүүлж, цаг алдалгүй авдаг болгосон. 4. Цаг агаарын текстэн мэдээний хэлбэрийг өөрчилж, зохиогчийн эрхтэй байгалийн гэрэл зурагтай, мэдээ гаргасан цаг уурчийн тайлбар видеотой мэдээг 162 мянган хэрэглэгчтэй "Ус цаг агаар, орчны мэдээ мэдээлэл" албан ёсны Фэйсбүүк хуудсаараа хүргэдэг боллоо. 5. Цаг агаарын мэдээний API ашиглалтыг нээлттэй болгосны дүнд И-Монгол, Малчин тв, Монгол айл апп, Зөгий.мн, Gogo.mn, Ikon.mn сайтууд ЦУОШГ-ын нээлттэй API-аар цаг агаарын мэдээ хүргэдэг боллоо.	-	-	-	-	-	-	

[illegible]

14	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны 21 дүгээр тэмдэглэл 2024-05-29 Дугаар 2024_21	21.4. танилцуулав. Үүнтэй холбогдуулан зуны улирлын цаг агаарын урьдчилсан мэдээгээр зарим нутгаар олон жилийн дунджаас ахиу хур тунадастай, гэнэтийн ус ихтэй аадар бороо үргэлжлэн орох төлөвтэй байгааг харгалзан үерийн далан, гол мөрний ойролцоо буусан айл өрхийг нүүлгэн шилжүүлэх, шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж, гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан, аймаг, нийслэлийн Онцгой комиссын дарга нарт, хэвлэл, мэдээллийн бүх хэрэгслээр цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээг тогтмол явуулж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газрын дарга Т.Ганзул нарт тус тус үүрэг болгов." (2024 оны зуны улирлын цаг агаарын урьдчилсан төлөвийн талаар)	2025 оны 6-р сарын 23-ны байдлаар Байгууллагын мэдээллийн хэрэгслүүд болох www.weather.gov.mn сайт болон "Ус, цаг агаарын мэдээ мэдээлэл" нэртэй 142.000 хэрэглэгч бүхий олон нийтийн сүлжээг ашиглан мэдээ мэдээллийг шуурхай хүргэж ажиллаа. Олон нийтийн сүлжээгээр "Ус цаг агаар, орчны мэдээ мэдээлэл" сошиал сувгаар нийт 1077 төрлийн зурган, 152 төрлийн видео, 43 төрлийн рийл мэдээлэл бэлтгэж, олон нийтэд түгээсэн. "Цаг уур, орчны шинжилгээний газар X /twitter/" хуудсаар 256 төрлийн мэдээ, мэдээлэл түгээсэн байна. Цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс сэрэмжлүүлэх мэдээ болон үер усны аюулаас сэрэмжлүүлэх мэдээг мэргэжилтэн инженерүүдийн тайлбартайгаар болон бусад хэлбэрээр 13 удаа бичлэг хэлбэрээр бэлтгэн олон нийтэд хүргэж ажиллаа. Цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн мэдээллийг хүргэхээс гадна өдөр тутмын мэдээлэл болох аймаг нийслэлийн төвүүдийн 3 хоногийн цаг агаарын урьдчилсан мэдээг 180 удаа, хоногийн нарийвчилсан мэдээг 180 удаа, дэлхийн 66 хотуудын 2 хоногийн цаг агаарын урьдчилсан мэдээг 70 удаа бичлэг байдлаар бэлтгэн өөрийн байгууллагын мэдээллийн хэрэгслүүд хүргэлээ. 2025 оны эхний хагас жилд нийт 13 удаагийн цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдэл ажиглагдсан. Давхардсан тоогоор анхааруулга мэдээ 737, сэрэмжлүүлэх мэдээ 61, урьдчилан сэргийлэх мэдээ 7 удаа гаргаж, олон нийтэд зарлан мэдээлэв. Анхааруулга мэдээг хүчтэй салхиар 76, шороон шуургаар 62, их бороогоор 4, шар усны үерээр 14, нойтон цасаар 86, цасан шуурга 72, ой хээрийн түймрээр 35, хүйтрэлтээр 24 удаа сэрэмжлүүлэх мэдээг хүчтэй салхиар 32, шороон шуургаар 7, их цасаар 5, цасан шуургаар 16, цочир хүйтрэлтээр 1 удаа Урьдчилан сэргийлэх мэдээг хүчтэй салхиар 3, шороон шуургаар 2, цасан шуургаар 2 удаа тус бүр бичиж олон нийтэд хүргэж ажилласан. Онцгой байдлын байгууллагатай хамтран цаг үеийн нөхцөл байдлаар талаарх мэдээ мэдээллийг тухай бүрд хэвлэлийн бага хурал зарлан мэдээллийг хүргэж ажилласан. Мөн Төрийн банкны Гялс апп хүргэж байна. Мөн ДДИШ ХХК-тай хамтын ажиллагаа эхлүүлж 180 мянган хэрэглэгчдэд шуурхай хүргэдэг болсон.	-	-	-	-	-	-	
15	Жил бүрийн 10.01-ны өдрөөс дараа жилд зохион байгуулах аялал жуулчлалын арга хэмжээний саналаа хүргүүлэх Монгол Улсад 2025 онд зохион байгуулах аялал жуулчлалын нэгдсэн цаглабарын талаар 2025-01-08 Дугаар 2025_2	22.10.2. Цаашид жил бүрийн 10.01-ны өдрөөс дараа жилд зохион байгуулах аялал жуулчлалын арга хэмжээний саналаа аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулгад хүргүүлж, нэгдсэн цаглабарын дагуу хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Ус цаг, уур орчны шинжилгээний салбарын хэмжээнд 2026 онд зохион байгуулах аялал жуулчлалын арга хэмжээний санал байхгүй тул хүргүүлээгүй болно.	-	-	-	Тийм	-	-	-
16	Зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хөнгөвчлөх, цахим хэлбэрт шилжүүлэх, холбогдох захиргааны хэм хэмжээний актуудыг хуульд нийцүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар 2025-03-26 Дугаар 2025_14	16.7.1 Зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох болон зөвшөөрлийн хугацаа сунгах асуудлыг Зөвшөөрлийн тухай хуульд заасан хугацаанд шийдвэрлэх, хууль зөрчсөн зөвшөөрөл олгох шат дамжлагыг нэмэгдүүлсэн захиргааны хэм хэмжээний акт баталсан зөрчлийг даруй арилгаж цаашид гаргахгүй байхад анхаарч ажиллахыг зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд	Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Зөвшөөрлийн тухай хуулиар Цаг уур, орчны шинжилгээний газар нь энгийн болон тусгай зөвшөөрөл олгох эрх олгогдоогүй болно.	-	-	-	Тийм	-	-	-

17	Улсын хэмжээнд хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн салбар дундын уялдааг хангах талаар 2025-07-23 Дугаар 2025_09	5.1.5. Төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй, шуурхай үзүүлэх, цахимжуулж, ажиллахыг яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт гэжээ.	"И-Монгол академи" УТУГ, Цаг уур, орчны шинжилгээний газартай хамтран Цаг уурын горимын мэдээний тодорхойлолтыг авах үйлчилгээг цахимжууллаа.Тус үйлчилгээгээр Цаг агаарын 138 өртөө, 180 харуулын ажиглалтаар агаар, хөрсний температур, даралт, чийг, хур тунадас, салхи, үзэгдлийн тоон мэдээ болон тодорхойлолт авах боломжтой. Мөн тус газрын харьяа Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатори нь үйл ажиллагаандаа D-LAB цахим бүртгэл, мэдээллийн системийг нэвтрүүлээ. Агаар, ус, хөрсний чанарын шинжилгээ хийлгэх, багаж шалгуулах, баталгаажуулах хэрэглэгч өөрийн хүсэлтийн явцыг хянах бүрэн боломжтойгоос гадна цахим системд төлбөр төлөх олон боломжит хувилбарыг бүрдүүлсэн юм.	-	-	-	-	-	-	-
18	Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, үнэлгээг ил тод нээлттэй мэдээлэхтэй холбоотой авах зарим арга хэмжээний талаар 2025-08-06 Дугаар 2025_11	9.1.1. Төрийн жинхэнэ албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн 2024 он болон 2025 оны эхний хагас жилийн тайлан, үнэлгээг байгууллагын цахим хуудсанд 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн дотор байршуулан олон нийтэд ил тод, нээлттэй болгохыг яамдын төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт даалгав.	Төрийн жинхэнэ албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн 2024 болон 2025 оны эхний хагас жилийн тайлан, үнэлгээг байгууллагын namem.gov.mn сайтад байршуулсан. Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторийн цахимжуулалтын ажил хийгдэж байна.	-	-	-	-	-	-	-
19	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар зөвлөмж, дүгнэлт гаргуулах талаар 2025-08-06 Дугаар 2025_11	9.7. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29.1 дэх хэсгийн хэрэгжилтийн дагуу Нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулахад цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар зөвлөмж, дүгнэлт гаргуулж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч, Засгийн газрын агентлагын дарга нар даалгав.	Нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар зөвлөмж, дүгнэлт гаргуулж ажиллана.	-	-	-	-	-	-	-
20	Монгол Улсын Ерөнхий сайдын албан даалгаврын хэрэгжилтийн талаар 2025-09-02 Дугаар 2025_15	10.1. Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 1,2,3,4 дүгээр албан даалгаварын хэрэгжилтийн явц, үр дүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авахыг Засгийн газрын агентлагийн дарга нарт даалгав. 1.1. удаашралтай, гүйцэтгэл нь хангалтгүй байгаа үүрэг даалгаварын хэрэгжилтийг эрчимжүүлж, шуурхай зохион байгуулах 1.2. хамтран хэрэгжүүлэхээр даалгасан үүрэг, даалгаврыг биелүүлэхдээ ажлын уялдаа, холбоог сайжруулж, харилцан мэдээлэл солилцон, нягт хамтран ажиллах	2025 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн ЦУОШГазрын даргын А/114 тоот тушаалын дагуу 8 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг нь 2024 оны 6 дугаар сарын 16, 23, 26, 7 дугаар сарын 09, 21, 23-ны өдөр нийт 6 удаа хуралдан асуудлыг хэлэлцэж ажиллалаа. Мөн салбарын хэмжээнд нийт 1893 албан хаагчаас 9 хувь буюу 171 албан хаагчийг цомхотгох шаардлагатай болсон. Ажлын хэсгийн санал дүгнэлтийн дагуу 2025 оны 08 дугаар сарын 04-ны өдрийн А/162 тоот тушаалаар орон нутгийн харьяа байгууллагуудын бүтэц, орон тоог баталж хэрэгжүүлэн ажиллаж байна.	-	-	-	-	-	-	-
21	Нээлттэй мэдээллийн ил тод байдлын 2024 оны хэрэгжилтэд хийсэн үнэлгээний тайлангийн талаар 2025-09-02 Дугаар 2025_15	10.4. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан нээлттэй мэдээллийг үнэн, зөв иргэдэд ойлгомжтой байдлаар цахим хуудсандаа болон нээлттэй мэдээллийн системд 2025 он 10 дугаар сарын 01-ний дотор бүрэн байршуулахыг Агентлагийн дарга нарт	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан нээлттэй мэдээллийг үнэн, зөв иргэдэд ойлгомжтой байдлаар байгууллагын namem.gov.mn болон gov.mn мэдээллийн системд хуулийн хугацаанд шинэчлэн байршуулсан.	-	-	-	-	-	-	-

22	Иргэдээс төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2025 оны эхний хагас жилийн тайлангийн талаар 2025-09-10 Дугаар 2025_16	28.1.3. иргэдээс гаргасан өргөдөл, гомдлын бүртгэл, ангилал, шийдвэрлэлтийг нэгдсэн санд тухай бүр бүртгүүлж байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагын дарг нарт	Байгууллагын namem.gov.mn болон gov.mn мэдээллийн системд хуулийн хугацаанд шинэчлэн байршуулсан.	-	-	-	-	-	-
23	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээний тайлангийн талаар 2025-09-10 Дугаар 2025_16	28.2. 1. Засгийн газрын агентлагын дарга нарт даалгав. 1.1.хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн төслийг боловсруулахдаа тухайн асуудлаар өмнө нь гаргасан шийдвэртэй утга агуулгын хувьд давхардуулан гаргахгүй байх, санхүү, төсвийн асуудлыг тусгасан, шалгуур үзүүлэлттэй, хэрэгжихүйц байхад анхаарах 1.2. хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг өмнөх тайлант хугацааны биелэлттэй харьцуулж, салбарын хэмжээнд нэгтгэн, хүрсэн үр дүнг товч тодорхой, үнэн, зөв тайлагнах 1.3.хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны зохицуулалтад шаардагдах төсөв хөрөнгийг шийдвэрлэх 1.4. хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтийг тайлагнахдаа салбар хоорондын уялдаа холбоог сайжруулж, хэрэгжилтийг тогтмол хянаж, үр дүнг нэмэгдүүлж ажиллах	Зөвлөмжийн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хийдэл, давхар, зөрчлийн талаарх ажлын хэсэг байгуулан санал дүгнэлтийг боловсруулж, тайлангийн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна.	-	-	-	-	-	-
24	Төсвийн зарцуулалт, сахилга батын тухай 2025-09-24 Дугаар 2025_18	10.3. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд ил тод, нээлттэй байхаар заасныг Төрийн албаны нууцын тухай хууль, журмыг зөрчин үндэслэлгүйгээр нууцалсан мэдээллийг ил болгох ажлыг шуурхай зохион байгуулахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагын дарга тэдгээрт харьяалагдах төрийн байгууллага нарт хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТЕГ-т 2025 оны 10-р сард багтаан танилцуулах	Цаг уур, орчны шинжилгээний газарт төрийн нууцад хамаарахгүй материал мэдээллийг төрийн нууцад оруулсан зүйл байхгүй болно.	-	-	-	-	-	-
25	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээний дүнгийн талаар 2025-09-24 Дугаар 2025_18	11.1.Хяналт-шинжилгээний тайлангийн дүнгийн мөрөөр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нарт үүрэг болгов.	Салбарын чиг үүргийн хүрээнд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын зохион байгуулан ажиллаж байна.	-	-	-	-	-	-

26	"Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-ний эхний хагас жилийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээний дүнгийн талаар 2025-09-24 Дугаар 2025_18	11.2. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг төлөвлөсөн зорилтот түвшинд хүргэх, эрчимжүүлэх, нөөцийг оновчтой хуваарилах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд болон аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох төрийн захиргааны байгууллагын дарга нарт даалгав.	Салбарын чиг үүргийн хүрээнд Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын зохион байгуулан ажиллаж байна.	-	-	-	-	-	-	-
27	Төрийн байгууллагуудын ашиглаж байгаа цахим систем, мэдээллийн санд дүн шинжилгээ хийж, систем хоорондын уялдаа холбоог ханган, давхардлыг арилгах, төрөөс иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлж байгаа цахим үйлчилгээг нэмэгдүүлэх ажлын хэрэгжилтийн талаар 2025-10-08 Дугаар 2025_20	16.4. 2025 онд багтаан дараах арга хэмжээг авахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга болон мэдээлэл хариуцагч байгууллагын удирдлагуудад даалгав. 1.эрхлэх асуудлын хүрээнд бүрдүүлсэн төрөлжсөн мэдээллийн сангийн мета өгөгдлийг "Төрийн мета-өгөгдлийн нэгдсэн сан"-д бүртгүүлэх	2025 оны 3 дугаар улирлын төрийн байгууллагын нээлттэй мэдээллийг gov.mn, shilen.gov.mn сайтуудад байршуулсан. Байгууллагын хэмжээнд Төрийн мета санд бүртгүүлэх, system.gov.mn бүртгүүлэн emongolia.mn-д Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 т заасны дагуу байгууллагын холбогдох мэдээ мэдээллийг оруулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.	-	-	-	-	-	-	-
		2.төрийн байгууллагуудын ашиглаж байгаа цахим систем болон мэдээллийн санг цахим систем (system.gov.mn)-д бүртгүүлэх		-	-	-	-	-	-	-
		3.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасны дагуу цахим хэлбэрээр үзүүлэх төрийн үйлчилгээг Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (emongolia.mn)" гэжээ.		-	-	-	-	-	-	-
Албан даалгавар										
		1.2.төрийн албан тушаалын чиг үүргийн давхарлыг арилгах, удирдах албан тушаалтны тоог бууруулах арга хэмжээ авч, байгууллагын орон тоог нэмэгдүүлэхтэй холбоотой аливаа шийдвэр гаргахгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоологж чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоо болон сул орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүй байхыг Засгийн газрын агентлагийн дарга нарт	2025 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн ЦҮОШГазрын даргын А/114 тоот тушаалын дагуу 8 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдсан ажлын хэсгийн санал дүгнэлтийн дагуу 2025 оны 08 дугаар сарын 04-ны өдрийн А/162 тоот тушаалаар орон нутгийн харьяа байгууллагуудын бүтэц, орон тоог баталж хэрэгжүүлэн ажиллаж байна.	-	-	-	-	-	-	-
		1.3. иргэддээ чин шударгаа үйлчилдэг, ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлэх зорилгод нийцүүлэн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг чанд мөрдүүлэх, хуулийг сурталчлан таниулах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг төрийн бүх шатны удирдлагад	Цаг уур, орчны шинжилгээний газрын даргэдэх Ёс зүйн дэд хороо нь нийт хамт олны саналаар сонгогдсон дарга-1, нарийн бичгийн дарга-1, 5 гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Weather.gov.mn сайтад Ёс зүйн дэд хороо буланд тогтмол мэдээ, мэдээлэл оруулан үйл ажиллагаагаа тогтмол явуулж байна.	-	-	-	-	-	-	-

28	Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 2025-07-25 Дугаар 2025_04	1.7. Төрийн албаны тухай хуульд зааснаас бусад үндэслэлээр төрийн албан хаагчдыг төрийн албанаас чөлөөлөхгүй, халахгүй, хуулиар чиг үүрэгт нь өөрчлөлт ороогүй тохиолдолд төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулахгүй байх, төрийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц өөрчлөгдсөн боловч албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг нь хэвээр хадгалагдсан үлдсэн төрийн жинхэнэ албан хаагчдыг чөлөөлөх, халах, албан тушаал бууруулах, шилжүүлэх шийдвэр гаргахгүй байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт	Албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.	-	-	-	-	-	-	-
		1.8. ажлын байрны нээлттэй мэдээлэлд үндэслэн төрийн албан хаагчдыг хувийн хэвшилд шилжүүлэн ажиллуулах санал боловсруулж, цалин хөлс, нийгмийн баталгааны талаарх мэдээллийг төрийн албан хаагчдад хүргэх уулзалт, арга хэмжээг Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим болон холбогдох бусад байгууллагатай хамтран зохион байгуулахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт	Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Монголын худалдаа аж үйлдвэрийн танхим 2025 оны 09 дүгээр сарын 29-ны өдөр хамтран зохион байгуулсан "Төрийн албанаас хувийн хэвшилд шилжин ажиллахыг дэмжих өдөрлөг"-н мэдээ мэдээллийг албан хаагчдад хүргэж, оролцох боломж нөхцөлөөр хангаж ажилласан.	-	-	-	-	-	-	-
		11.4. уур амьсгалын өөрчлөлтийн өнөөгийн болон хэтийн төлөвийг олон загвараар нарийвчлан гаргах, цаг агаарын урт хугацааны урьдчилсан мэдээг тооцоолох чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор өндөр хүрдны суперкомпьютерийг 2025.09.20-ны өдрийн дотор ажиллуулж эхлэх	Монгол Улсын цаг уурын салбарт супер компьютерын дараагийн үеийн технологийг нэвтрүүлэх үйл ажиллагааны нээлт 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр болсон. Нээлтийн үйл ажиллагаанд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Монгол дахь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Суурин төлөөлөгч Матилда Димовска, ЦУОШГ-ын дарга Э.Баттулга нарын албаны хүмүүс оролцсон. Уур амьсгалын Ногоон сангийн санхүүжилтээр Монгол Улсын Засгийн газар болон НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хамтран хэрэгжүүлж буй "Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавх болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь" (АДАПТ) төслийн хүрээнд шинэ үеийн супер компьютерын технологийг нэвтрүүлсэн. 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдрөөс ажиллуулж эхэлсэн.	-	-	-	-	-	-	-